ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр Дугаар 6/12 Баянтал сум

Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан
тушаалд томилох тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

2. Нэргүй овогтой Мөнгөнцэцэгийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөр эхлэн Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалд томилсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Л.Отгонпүрэв | (Санхүү албаны дарга) |
| Гишүүн: | Н.Сарантуяа | (Аж ахуйн нярав) |
| Нарийн бичгийн дарга: | Э.Буянтогтох | (Нийгмийн бодлого хавсран гүйцэтгэгч) |

3. Н.Мөнгөнцэцэгийн цалинг ТҮ-5 шатлалаар тогтоон үндсэн цалин (635776) /зургаан зуун гучин таван мянга долоон зуун далан зургаа/ төгрөгөөр удаан аж төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл үндсэн цалингийн 25 хувь тус тус бодож, олгож байхыг Санхүү албаны нягтлан бодогч /Х.Ариунгуа/-д зөвшөөрсүгэй.

3. Н.Мөнгөнцэцэг ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА В.ГАНТУЯА

D;My ducoment/zahiramj/ajil2022.doc

4222101158

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 25 өдөр Дугаар Б/15 Баянтал сум

С.Оюунтүлхүүрийг төрийн жинхэнэ албаны
туслах түшмэлийн албан тушаалд
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 194 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

3. Төрийн албан хаагчийн тусгай шалгалт өгч тэнцсэн Сэрээдоржийн Оюунтүлхүүрийг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан албан тушаалд 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс томилсугай.

2. С.Оюунтүлхүүрийн үндсэн цалинг ТЗ-4-3 шатлалаар тогтоон үндсэн цалин 686,678 (зургаан зуун наян зургаан мянга зургаан зуун далан найм) төгрөгөөр, төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувиар тус тус тооцож олгохыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.

5. С.Оюунтүлхүүрт ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА В.ГАНТУЯА

4221 0168